

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/127-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Ц.Ундраа Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:undraats@audit.gov.mn">undraats@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

–	
1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19-20

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗД	Засаг дарга
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Д.ОДГЭРЭЛ ТАНАА

2024.2.23 № САА-2024/127-ТТН-СТН-ТЦУЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус Эрүүл мэндийн төвийн бараа материалын дансанд Ковид 19 цар тахал өвчинтэй холбоотойгоор өмнөх онуудад ЭМЯ, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгсөн нийт 5,010.9 мянган төгрөгийн эм, хамгаалах хэрэгсэл бүртгэлтэй байна.

Эдгээр бараа материалын ашиглалтын хугацаа дуусаж, хадгалалтын нөхцөл алдагдан ашиглагдахгүй болох эрсдэлтэй байна.

## **Аудитын гол асуудал**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 6 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>434,941,815.03</b>	<b>516,402,007.19</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>290,223,377.17</b>	<b>274,172,819.36</b>
31200	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>290,223,377.17</b>	<b>274,172,819.36</b>
31210	<b>Төгрөг</b>	<b>290,223,377.17</b>	<b>274,172,819.36</b>
31211	Төрийн сангийн харилцах	290,223,377.17	274,172,819.36
33	<b>АВЛАГА</b>	<b>0</b>	<b>107,899,277.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0	101,686,193.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0	6,213,084.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>144,718,437.86</b>	<b>134,329,910.83</b>
35100	<b>Түүхий эд материал</b>	<b>101,406,720.77</b>	<b>62,898,935.80</b>
35130	Эм боох материал	101,406,720.77	62,898,935.80
35300	Бэлэн бүтээгдэхүүн	12,252,721.09	46,606,348.03
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>31,058,996.00</b>	<b>24,824,627.00</b>
35410	Бичиг хэргийн материал	2,250,040.00	5,779,960.00
35420	Аж ахуйн материал	19,308,109.00	15,965,380.00
35440	Түлш, шатах тослох материал	2,515,684.00	1,525,000.00
35460	Хүнсний материал	6,985,163.00	1,554,287.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>828,898,008.21</b>	<b>792,050,900.90</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>828,898,008.21</b>	<b>792,050,900.90</b>
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>786,093,608.21</b>	<b>747,466,500.90</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	772,988,093.00	772,988,093.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-470,092,645.35	-486,006,153.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	135,612,131.00	135,612,131.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-133,424,631.28	-134,153,797.96
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	961,522,226.31	718,609,613.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-538,025,041.04	-310,907,260.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,676,325.00	83,930,564.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,539,459.77	-45,623,439.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,017,300.00	20,017,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,640,689.66	-7,000,550.24
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>42,804,400.00</b>	<b>44,584,400.00</b>
39301	Программ хангамж	250,000.00	2,122,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	-342,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,804,400.00	42,804,400.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,263,839,823.24</b>	<b>1,308,452,908.09</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>21,246,355.36</b>	<b>25,613,786.27</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>21,246,355.36</b>	<b>25,613,786.27</b>
41300	<b>Өглөг</b>	<b>21,246,355.36</b>	<b>25,613,786.27</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	801,121.30	25,613,786.27
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,242,593,467.88</b>	<b>1,282,839,121.82</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,242,593,467.88</b>	<b>1,282,839,121.82</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	757,270,416.00	757,270,416.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	757,270,416.00	757,270,416.00
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-1,187,012,022.45</b>	<b>-1,146,766,368.51</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,866,264,620.92	-1,187,012,022.45
51220	Тайлант үеийн үр дүн	679,252,598.47	40,245,653.94

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,672,335,074.33	1,672,335,074.33
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,263,839,823.24</b>	<b>1,308,452,908.09</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	/төгрөгөөр/ ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,681,243,869.78</b>	<b>2,229,106,839.50</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>889,883,042.98</b>	<b>300,742,610.86</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>889,883,042.98</b>	<b>300,742,610.86</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>19,600,104.00</b>	<b>269,197,236.40</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,600,104.00	269,197,236.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	740,508,672.66	11,982,618.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	129,774,266.32	19,562,756.06
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,791,360,826.80</b>	<b>1,928,364,228.64</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>226,316,926.80</b>	<b>235,300,199.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226,316,926.80	235,300,199.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,565,043,900.00</b>	<b>1,693,064,029.64</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,565,043,900.00	1,693,064,029.64
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,001,991,271.31</b>	<b>2,188,861,185.56</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,001,991,271.31</b>	<b>2,188,861,185.56</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,001,991,271.31</b>	<b>2,188,861,185.56</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,013,539,895.98</b>	<b>1,150,774,003.45</b>
210101	Үндсэн цалин	681,682,426.36	638,394,610.12
210102	Нэмэгдэл	265,486,232.39	413,865,607.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,514,000.00	9,277,041.73
210104	Урамшуулал	54,857,237.23	89,236,744.18
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>129,657,241.45</b>	<b>148,003,068.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	94,185,396.38	108,449,372.66
210202	Тэтгэмжийн даатгал	9,109,322.44	9,888,498.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,914,346.17	7,910,398.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,661,146.81	1,978,198.79
210205	Эрүүл мэндийн даатгал	17,787,029.65	19,776,599.56
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>223,303,795.80</b>	<b>232,735,199.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,998,934.94	20,507,444.53
210302	Түлш, халаалт	197,681,332.86	197,923,626.47
210303	Цэвэр, бохир ус	9,623,528.00	14,304,128.00

2104	Хангамж, бараа материалын зардал	71,278,247.43	47,502,693.68
210401	Бичиг хэрэг	5,096,720.00	8,019,500.00
210402	Тээвэр, шатахуун	20,255,000.00	21,990,684.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,041,537.43	6,249,009.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,467,000.00	2,368,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,417,990.00	8,875,200.00
2105	<b>Норматив зардал</b>	<b>231,601,385.82</b>	<b>495,806,349.56</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	191,571,500.82	458,584,978.56
210502	Хоол, хүнс	29,907,635.00	36,657,371.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,122,250.00	564,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>70,813,004.00</b>	<b>33,231,386.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,870,700.00	2,081,800.00
210604	Урсгал засвар	47,942,304.00	31,149,586.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,696,000.00</b>	<b>4,452,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,696,000.00	4,452,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>42,453,236.38</b>	<b>1,579,325.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,828,661.38	1,315,825.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	73,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,900.00	150,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	40,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>216,648,464.45</b>	<b>74,776,960.71</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,933,300.00	6,076,335.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	205,715,164.45	68,700,625.71
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>679,252,598.47</b>	<b>40,245,653.94</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>679,252,598.47</b>	<b>40,245,653.94</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН /төгрөгөөр/
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,384,524,235.21</b>	<b>2,089,662,188.04</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>23,641,408.41</b>	<b>262,984,152.40</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>23,641,408.41</b>	<b>262,984,152.40</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>23,641,408.41</b>	<b>262,984,152.40</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,600,104.00	262,984,152.40
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,360,882,826.80</b>	<b>1,826,678,035.64</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>226,316,926.80</b>	<b>235,300,199.00</b>

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226,316,926.80	235,300,199.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,134,565,900.00</b>	<b>1,591,377,836.64</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,134,565,900.00	-1,591,377,836.64
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,800,196,358.04</b>	<b>2,085,841,845.85</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,800,196,358.04</b>	<b>2,085,841,845.85</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,800,196,358.04</b>	<b>2,085,841,845.85</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>997,015,711.92</b>	<b>1,167,168,060.01</b>
210101	Үндсэн цалин	665,158,242.30	654,788,666.68
210102	Нэмэгдэл	265,486,232.39	413,865,607.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,514,000.00	9,277,041.73
210104	Урамшуулал	54,857,237.23	89,236,744.18
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>129,657,241.45</b>	<b>148,003,068.16</b>
210201	Тэтгэврийн даатгал	94,185,396.38	108,449,372.66
210202	Тэтгэмжийн даатгал	9,109,322.44	9,888,498.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,914,346.17	7,910,398.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,661,146.81	1,978,198.79
210205	Эрүүл мэндийн даатгал	17,787,029.65	19,776,599.56
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>226,316,926.80</b>	<b>231,800,199.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,998,934.94	19,572,444.53
210302	Түлш, халаалт	200,694,463.86	197,923,626.47
210303	Цэвэр, бохир ус	9,623,528.00	14,304,128.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,399,047.43</b>	<b>43,006,709.68</b>
210401	Бичиг хэрэг	6,131,520.00	9,502,220.00
210402	Тээвэр, шатахуун	21,500,000.00	21,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,041,537.43	6,222,609.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,226,000.00	2,646,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,499,990.00	3,635,030.00
2105	<b>Норматив зардал</b>	<b>231,321,501.06</b>	<b>450,665,572.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	201,225,561.06	414,537,577.00
210502	Хоол, хүнс	19,759,140.00	31,264,995.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,336,800.00	4,863,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>102,381,393.00</b>	<b>33,063,977.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,254,100.00	3,350,500.00
210604	Урсгал засвар	91,127,293.00	29,713,477.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,696,000.00</b>	<b>4,452,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,696,000.00	4,452,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>58,546,236.38</b>	<b>1,605,725.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,592,661.38	1,315,825.00

210803	Даатгалын үйлчилгээ	160,000.00	73,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	78,675.00	150,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	75,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	26,400.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,862,300.00</b>	<b>6,076,335.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,862,300.00	6,076,335.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>584,327,877.17</b>	<b>3,820,342.19</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>294,104,500.00</b>	<b>19,870,900.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>294,104,500.00</b>	<b>19,870,900.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>294,104,500.00</b>	<b>19,870,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	294,104,500.00	19,870,900.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-294,104,500.00</b>	<b>-19,870,900.00</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>290,223,377.17</b>	<b>-16,050,557.81</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	290,223,377.17
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	290,223,377.17	274,172,819.36

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	757,270,416.00	1,672,335,074.33	-1,866,264,620.92	563,340,869.41
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-1,866,264,620.92	563,340,869.41
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	679,252,598.47	679,252,598.47
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-1,187,012,022.45	1,242,593,467.88
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-1,187,012,022.45	1,242,593,467.88
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-1,187,012,022.45	1,242,593,467.88
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	40,245,653.94	40,245,653.94
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	757,270,416.00	1,672,335,074.33	-1,146,766,368.51	1,282,839,121.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,100,348,100.00</b>	<b>1,870,412,546.85</b>	<b>229,935,553.15</b>	<b>89</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,100,348,100.00</b>	<b>1,870,412,546.85</b>	<b>229,935,553.15</b>	<b>89</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,100,348,100.00</b>	<b>1,870,412,546.85</b>	<b>229,935,553.15</b>	<b>89</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,318,484,600.00</b>	<b>1,167,168,060.01</b>	<b>151,316,539.99</b>	<b>89</b>
210101	Үндсэн цалин	772,034,300.00	654,788,666.68	117,245,633.32	85
210102	Нэмэгдэл	365,501,300.00	413,865,607.42	-48,364,307.42	113
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,182,000.00	9,277,041.73	4,904,958.27	65
210104	Урамшуулал	166,767,000.00	89,236,744.18	77,530,255.82	54
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>175,078,700.00</b>	<b>148,003,068.16</b>	<b>27,075,631.84</b>	<b>85</b>
210201	Тэтгэврийн даатгал	130,618,900.00	108,449,372.66	22,169,527.34	83
210202	Тэтгэмжийн даатгал	11,114,700.00	9,888,498.57	1,226,201.43	89
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,892,500.00	7,910,398.58	982,101.42	89
210204	Ажилгүйдлийн даатгал	2,223,300.00	1,978,198.79	245,101.21	89
210205	Эрүүл мэндийн даатгал	22,229,300.00	19,776,599.56	2,452,700.44	89
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>46,500,300.00</b>	<b>43,006,709.68</b>	<b>3,493,590.32</b>	<b>92</b>
210401	Бичиг хэрэг	9,800,000.00	9,502,220.00	297,780.00	97
210402	Тээвэр, шатахуун	22,536,100.00	21,000,000.00	1,536,100.00	93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,538,900.00	6,222,609.68	-1,683,709.68	137
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,625,300.00	2,646,850.00	-21,550.00	101
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,000,000.00	3,635,030.00	3,364,970.00	52
2105	<b>Норматив зардал</b>	<b>455,648,100.00</b>	<b>450,665,572.00</b>	<b>4,982,528.00</b>	<b>99</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	419,507,800.00	414,537,577.00	4,970,223.00	99
210502	Хоол, хүнс	31,265,000.00	31,264,995.00	5.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,875,300.00	4,863,000.00	12,300.00	100
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>85,534,200.00</b>	<b>48,114,877.00</b>	<b>37,419,323.00</b>	<b>56</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,140,000.00	21,901,400.00	26,238,600.00	45
210604	Урсгал засвар	37,394,200.00	26,213,477.00	11,180,723.00	70
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,559,700.00</b>	<b>4,452,200.00</b>	<b>1,107,500.00</b>	<b>80</b>
210702	Дотоод албан томилолт	5,559,700.00	4,452,200.00	1,107,500.00	80
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,730,000.00</b>	<b>2,925,725.00</b>	<b>804,275.00</b>	<b>78</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,025,000.00	1,362,225.00	662,775.00	67
210803	Даатгалын үйлчилгээ	164,700.00	73,200.00	91,500.00	44
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,300.00	150,300.00	0.00	100

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	90,000.00	40,000.00	50,000.00	44
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,300,000.00	1,300,000.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,812,500.00	6,076,335.00	3,736,165.00	62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,812,500.00	6,076,335.00	3,736,165.00	62
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,100,348,100.00</b>	<b>1,854,361,989.04</b>	<b>245,986,110.96</b>	<b>9055 88</b>
33	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,545,686,900.00</b>	<b>1,591,377,836.64</b>	<b>-45,690,936.64</b>	<b>103</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,545,686,900.00	1,591,377,836.64	-45,690,936.64	103
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>554,661,200.00</b>	<b>262,984,152.40</b>	<b>291,677,047.60</b>	<b>47</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	264,437,800.00	262,984,152.40	1,453,647.60	99
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	290,223,400.00			
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		290,223,377.17		
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		274,172,819.36		
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>61</b>	<b>54</b>		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	45	40		
620003	Үйлчлэх ажилтан	15	13		
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>61</b>	<b>54</b>		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	48	43		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	11		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын эрүүл мэндийн төв нь “Үйлчлүүлэгчдэд ээлтэй, тэгш хүртээмжтэй тусламж үйлчилгээг хүргэж, хүн амын эрүүл мэндийг сайжруулж, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- *Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ;*

- Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж;
- Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэмцсэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;
- Өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;
- Өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэх мэт.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол улсын Засгийн газрын 2023 оны 06 сарын 21-ний өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ЭМДҮЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”, 8 дугаар тогтоол батлагдсан,
- ЭМДҮЗ-ийн 2023 оны 11 сарын 17-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Багц төлбөрийн хэмжээ”-ний журам баталсан гэх мэт.


Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ, аймгийн ЭМГ-аас хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ыг мөрдөн ажиллаж байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.


Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,308,452.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 44,613.1 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	290,223.4	274,172.8	16,050.6
Авлага		107,899.3	107,899.3
Бараа материал	144,718.4	134,329.9	-10,388.5
Үндсэн хөрөнгө	828,898.0	792,050.9	-36,847.1
Нийт хөрөнгө	<b>1,263,839.8</b>	<b>1,308,452.9</b>	<b>44,613.1</b>
Өр төлбөр	21,246.3	25,613.8	4,367.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,242,593.5	1,282,839.1	40,245.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	<b>1,263,839.8</b>	<b>1,308,452.9</b>	<b>44,613.1</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд: Авлага дансанд ЭМДС-аас 2023 оны 11, 12 дугаар сарын санхүүжилтийн 107,899.3 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан,



- Бараа материалын дансны үлдэгдэл 134,329.9 мянган төгрөг болж 10,388.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 559,817.9 мянган төгрөгийн бараа материал орлого авч, 570,206.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 792,050.9 мянган төгрөг болж 36,847.1 мянган төгрөгөөр буурсан нь 31,853.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 275,639.9 мянган төгрөгийн хөрөнгө актлан, 68,700.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 25,613.8 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь тайлант онд үзүүлсэн эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийг ЭМДС-аас дутуу төвлөрүүлснээс тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-ийн санхүүжилтээс 996,144.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 506,383.1 мянган төгрөг, нийт **1,502,527.2** мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас ЭМДС-ийн санхүүжилтийн орлогыг 549,542.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн **1,545,686.9** мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлогыг 241,945.3 мянган төгрөгөөр бууруулан **264,437.8** мянган төгрөгөөр, өмнөх оны дансны үлдэгдлээс **290,223.4** мянган төгрөг, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг **2,100,348.1** мянган төгрөгийн баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМДС-ийн санхүүжилтээр **1,591,377.8** мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос **262,984.1** мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс **16,050.5** мянган төгрөг зэрэг нийт **1,870,412.5** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, урсгал үйл ажиллагаанд зарцуулснаар төсвийн гүйцэтгэл **1,870,412.5** мянган төгрөг буюу 89.0 хувьтай тайлагнагдсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Туслах үйл ажиллагааны зардал /80102/	264,437.8	262,546.3	-1,891.5	99.3

2	Эрүүл мэндийн даатгалын сангаас /80302/	656,922.0	658,016.6	1,094.6	101.0
3	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ /81603/	1,178,988.3	949,849.6	-229,138.7	80.5
	<b>Дүн</b>	<b>2,100,348.1</b>	<b>1,870,412.5</b>	<b>-229,935.6</b>	<b>89.0</b>



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сайхан сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд төсвийн хөрөнгөөр хэвтэн эмчлүүлэгчийн хоол хүнсний материал худалдан авахаар 31,265.0 мянган төгрөг, шатахуун худалдан авахаар 22,536.1 мянган төгрөг батлагдсан байна.

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад байршуулан сонгон шалгаруулалт зарлалгүйгээр бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдтэй шууд худалдан авах гэрээг байгуулан ажилласан байна.

Ник ХХК-ийн Сайхан сум дахь салбараас шатахуун, тослох материал худалдан авах гэрээ, Жавхлант заяа ХХК-аас хүнс, хангамжийн материал нийлүүлэх гэрээг тус тус байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр



- Байгууллагын батлагдсан төсөв, 1 дүгээр сар.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.



#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Шууд худалдан авах босго үнээс давсан / оны эхэнд баталсан төсвийн хуваариар/ 22.536.1 мянган төгрөгийн шатахуун, 31,265.0 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 2: "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 283,315.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт 1, албан шаардлага 2, зөвлөмж 1 тус тус өгөгдсөн байна.

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн зөрчлийг давтан гаргаж, хэрэгжилт 75.0 хувьтай байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,179.8	1	3,179.8	100
Албан шаардлага	2	240,961.0	1	219,714.7	50
Зөвлөмж	1	39,174.5	1	39,174.5	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>283,315.3</b>	<b>3</b>	<b>283,315.3</b>	<b>75.0</b>



Шийдвэрлэлт: Өмнөх аудитаар өгсөн төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлагыг биелүүлээгүй тус эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Э.Амарзаяад холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,749.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тавилга, тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийн дансыг буруу сонгож, элэгдлийн зардлыг **815.2** мянган төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан,
2. Санхүүгийн байдлын тайлангаас үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдэл нь **1,000.0** мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн,
3. Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал засварын зардлын **934.0** мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд бүртгэн тайлагнасан байна.

Аудитаар нийт 12,390.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,130.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 11,260.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

#### 5.1 Төлбөрийн акт


1. Нягтлан бодогч Б.Ууганцэцэг, А.Амарзаяа, дүн бүртгэгч Б.Энхцэцэг, хүний нөөц Н.Оюунтунгалаг, нярав Д.Отгонцэцэг нарын илүү цагийн нэмэгдэл хөлсийг тогтоосон хувь хэмжээнээс илүү тооцон, нийт 1,130.2 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3 дахь "Илүү цагаар... ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон илүү цагийн хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас эргэлтийн эмийн сангийн эмийн төлбөрийн 11,260.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогч Э.Амарзаяад холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дансыг буруу сонгон бүртгэсэн	1	815.2			1	815.2	1	815.2				
Санхүүгийн байдлын тайлангаас үндсэн хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	1,000.0			1	1,000.0	1	1,000.0				
Урсгал засварын зардлыг гэрэл цахилгааны зардалд бүртгэсэн	1	934.0			1	934.0	1	934.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,749.2</b>			<b>3</b>	<b>2,749.2</b>	<b>3</b>	<b>2,749.2</b>				

### **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Илүү цагийн нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон	1	1,130.2	1	1,130.2							
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс эргэлтийн эмийн санд өр төлбөр үүсгэсэн	1	11,260.3			1	11,260.3			1	1	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>12,390.5</b>	<b>1</b>	<b>1,130.2</b>	<b>1</b>	<b>11,260.3</b>			<b>1</b>	<b>1</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг 5 удаа хоцроон тайлагнасан	1							1
<b>Дүн</b>	<b>1</b>							<b>1</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	53,801.1			1	53,801.1		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>53,801.1</b>			<b>1</b>	<b>53,801.1</b>		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>53,801.1</b>			<b>1</b>	<b>53,801.1</b>		<b>1</b>